



## НИЙСЛЭЛИЙН БАЯНЗУРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 8/66

Улаанбаатар хот

### Г Комисс томилох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.4, Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Нано бриллиант конструкшн” хязгаарлагдмал хариуцлагатай компани хийж гүйцэтгэсэн Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооны спорт талбайн тохиижилтын ажлыг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг хүлээн авч баримтжуулан акт үйлдэж, цаашид ашиглалт хамгаалалтын асуудалд хяналт тавьж ажиллахыг Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооны Засаг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Уранчимэг/-дааалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Б.Бат-Эрдэнэ/-т дааалгасугай.

ДАРГА



И.БАТТӨГС